

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ

Мэдээлэл 1.А

Тогтвортой хөгжлийн боловсролын талаар өргөн ойлголттой болохын тулд ЭНЭ ЯАГААД ҮҮСЭХ БОЛОВ? гэдэг асуултыг тавих хэрэгтэй.

- 1972 онд Шведийн нийслэл Стокголом хотод болсон НҮБ-ын “Хүний хүрээлэн буй орчин” сэдэвт хуралдаан болж, хүрээлэн байгаа орчны доройтлын асуудалд хариу өгөх, нийгэм- экологийн асуудал зөвхөн хөгжилтэй орнуудад төдийгүй хөгжиж байгаа орнуудад нэгэн адил хурцадсан гэдгийг тус тус хүлээн зөвшөөрч, байгалийн нөөцийг оновчтой ашиглах, байгаль хамгаалах салбарын олон улсын стратегийг боловсруулан гаргасан.
- 2002 онд Өмнөд Африкийн Иоханнесбург хотноо даян дэлхийн тогтвортой хөгжлийн дээд хэмжээний уулзалт зохион байгуулагдаж, энэхүү уулзалтаар эдийн засаг, нийгмийн хөгжил, хүрээлэн буй орчныг хамгаалах харилцан уялдаа бүхий, бие биеэ тэтгэх тогтвортой хөгжлийн үндэс суурийг бэхжүүлэх хамтын үүрэг хариуцлагыг тунхаглаж тогтвортой хөгжлийн боловсролын олон улсын арван жилийг зарлахыг уриалан “Иоханнесбургийн тунхаглал” зэрэг баримт бичгүүдийг баталсан байдаг. *Миний өнөөдрийн үйл ажиллагаа нь бидний маргаашийн ирээдүйд эерэгээр эсвэл сөргөөр нөлөөлж байдаг учир цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулиуд, их дээд сургуулиуд болон боловсролын байгууллагууд нь хүүхэд залуучуудыг хариуцлагатай, дэлхийн иргэн болгон төлөвшүүлэх, хамтран аж төрөх, хамтран ажиллах, суралцахад сургах, уур амьсгалын өөрчлөлт зэрэг глобал асуудлуудыг хамтдаа шийдэхэд сургахад чиглэн ажиллах хэрэгтэй болж байгаа юм.*
- 2007 онд Энэтхэг улсад болсон Тогтвортой хөгжлийн олон улсын 5-р бага хурлаас гаргасан тунхаглалд *“Боловсролоор дамжуулан бид асуудлыг шийдэж, бэрхшээлийг давж, соёлын өргөн онцлогуудыг хүндэтгэн бие биенээ гэсэн энх тайван нийгмийг бий болгож чадна. Нийтийн эрх ашгийн төлөө бид бие хүний болоод үндэсний сонголтыг хийх болно. Хувь хүмүүс, Засгийн газрууд, аж ахуй нэгжүүд, байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа нь хүн төрөлхтний ирээдүйд үнэтэй хувь нэмэр үзүүлж байгаад өөрсдөөрөө бахархах болно”* гэж заажээ.

Тогтвортой хөгжлийн боловсрол нь хүрээлэн буй орчны асуудал болох ус, уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон төрөл зүйл, тогтвортой үйлдвэрлэл болон хэрэглээгээр хязгаарлагдах бус ядууралтай тэмцэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх, нийгмийн өөрчлөлтийн удирдлага зэрэг хөгжлийн эдийн засгийн аспектиуд болон соёлын олон төрөл зүйлийг хамгаалан авч үлдэх, жендерийн эрх тэгш байдлыг хангах, ДОХ-той тэмцэх, ард түмний уламжлалт зан үйлийг хамгаалах зэрэг нийгмийн асуудлуудыг хамардаг.

Тогтвортой хөгжлийн боловсрол нь **харилцан уялдаатай, хариу үйлдэлтэй, хариуцлагатай** байхыг шаарддаг. Боловсролоор дамжуулан хүн төрөлхтний аж байдлыг экологийн цэвэр орчин, эдийн засгийн шударга байдал, тогтвортой аж төрөх ёс болон бүх амьд амьтад харилцан шүтэлцээтэй амьдрах боломжийг бий болгох асуудлыг шийдвэрлэж, бэрхшээлийг давж, соёлын өргөн онцлогуудыг хүндэтгэн бие биенээ гэсэн энх тайван нийгмийг бий болгож чадна.

Сүүлийн жилүүдэд байгаль орчны боловсролын тухай ойлголт нь Тогтвортой хөгжлийн боловсролруу шилжиж байна. Уламжлал ёсоор байгаль орчны боловсрол нь аливаа зүйлийг үнэ цэнээр нь ангилах, мэдлэгт суурилсан хандлага, байгаль орчинд эерэгээр нөлөөлөх хүчин зүйлсийг төлөвшүүлэх болон бусад асуудлаас урьтаж байгаль орчны асуудлыг шийдвэрлэхэд суурилсан байдаг. Байгаль орчны боловсролд эдгээр зарчмуудыг ач холбогдлоор нь ангилсан байх шаардлагатай. Сүүлийн жилүүдэд судлаачид ТХБ нь байгаль орчны боловсролыг шинээр эхлүүлж, шинээр тодорхойлон болсон. Тухайбал: тогтвортой байдал болон хөгжлийн хооронд тогтсон холбоо байхгүй учраас ТХБ-ыг тухайн нийгэм, соёл, газарзүй, түүхэн нөхцөл байдал, харилцан хамаарлаас ургуулан гаргаж, практик дээр хэрэгжүүлэх хэрэгтэй юм. Энэ утгаараа ТХБ нь байгаль орчны боловсролоос илүү өргөн хүрээнд тодорхойлогдон, байгаль экологи, эдийн засаг, нийгмийн хөгжлийг холбосон хүний хөгжил болоод байгаль орчныг хамгаалах тэнцвэрийг бий болгож байгаагаараа онцлог юм.

Эх сурвалж:

Лейф Остлсон, Злас Сандолл, Иохан Охман, Тогтвортой хөгжлийн боловсрол. Бит пресс, Улаанбаатар, 2014 он

БСШУЯ, Ерөнхий боловсролын сургалт, үйл ажиллагаанд тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг тусган, хэрэгжүүлэх үндсэн чиглэл, шаардлага. ВСИ, Улаанбаатар, 2016 он

ЮНЕСКО, Цөлийн цэцэрлэг: Цөлжилтийг сааруулах боловсролын гарын авлага. Улаанбаатар, 2016 он

<http://www.unesco.mn/p/47>

ГАЗАРЗҮЙН СУРГАЛТАД ТХБ-ЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, АГУУЛГЫГ ТУСГАХ НЬ

Мэдээлэл 1.Б

Хичээл заах үед тулгардаг түгээмэл хүндрэл бол сурагчийн “Би ойлгохгүй байна” гэсэн өгүүлбэрт хариулт өгөх юм. “Би яах ёстой вэ” гэдэг асуултад багш болгон ордог. Энэ тохиолдолд бодоод суух цаг байхгүй, хариулыг тэр даруй өгөх хэрэгтэй. Хариуг хэлэхдээ хэд хэдэн хүчин зүйлсийг бодолцох шаардлагатай болдог. Жишээ нь: хэн асуулыг асуув, ямар түвшний сурагч вэ, энэ асуулыг асууж байсан эсэх, ямар асуултауд ойлгоход бэрхшээлтэй байдаг гэх мэт. Эдгээр чадварыг номноос сурах боломжгүй. Асуултын хариулт бүр тодорхой байх хэрэгтэй. Асуултын хариулт практик туршлагаас үндэслэн гарсан гэж хариулж болох юм. Практик чадвар нь зааж буй хичээлийг онцлог болгож сурагч бүр өөрсдийнхөө чадавхи болон суурь мэдлэгт үндэслэн суралцах илүү оновчтой нөхцөлөөр хангадаг байна. Энэхүү мэдлэг нь урт хугацааны явцад дадлагажиж байж олж авдаг чадвар гэж хэлж болно. Иймд сургалтаар зөв дадал, хэвшлийг олгох нь ирээдүй хойчид ТХБ-ыг олгож буй багшийн чухал ажлуудын нэг болно.

Байгаль орчныг хамгаалах асуудлыг үгнээс үйл хөдлөл болгох нь

Уул уурхайн олборлолт, байгаль орчны нөхөн сэргээлт, хог хаягдлын менежмент, хот төлөвлөлт, барилгын хөгжил зэрэгт байгаль орчинтой уялдсан ажлуудад хөрөнгө их зарцуулдаг ч байгалийн тэнцвэрт байдал, унаган төрх, хөрс, ургамал, амьтан зэрэгт сөрөг нөлөө ихээр үзүүлж байдаг. Байгаль, нийгэм, эдийн засгийн хөгжлийг тогтвортойгоор ирээдүй

хойч үедээ өвлүүлэхийн тулд бид ярихаас илүүтэйгээр үйлдэл хийх шаардлага жилээс жилд тулгарч байна.

Тогтвортой хөгжлийн асуудлыг макро түвшинд авч үзвэл:

1. Уламжлалт аж төрөх, ахуйд амьдралын хэв маягт гарч буй өөрчлөлт

Баримт 1.1.

Монголчуудын хувьд “Байгаль орчныг хамгаалах” гэдэг ухагдахуун нь байгалийн зүйд захирагдан, байгаль орчинтойгоо ухаалгаар зохицон амьдрах, газар дэлхийгээ эхтэйгээ зүйрлэн, хүндэтгэн дээдлэх, түүнд хүмүүнлэг сэтгэлээр хандан, амьтан ургамлыг нь энэрэн хайрлах, экологийн өндөр ёс зүйтэй байж нөөц баялгийг нь ариглан гамнахын нэр байж ирсэн бөгөөд “биологийн олон янз байдал”, тэдгээрийн салшгүй хүйн холбоог зан үйл, шашин шүтлэгээрээ дамжуулан эртнээс ухамсарлаж ирсэн хэдий ч зах зээлийн харилцаанд шилжих шилжилт, эрдэс баялагт тулгуурласан эдийн засгийн бодлого, даяаршлын нөлөөгөөр байгалийн нөөцийн зохистой ашиглалт, хамгааллын асуудал нь төр нийгмийн санаа зовоосон асуудлын нэг болж байна.

Баримт 1.2.

Монгол орны амьтан, ургамлын зүйлийн хомсдолд нөлөөлж байгаа гол хүчин зүйлүүдэд амьдрах орчны хумигдал, тасархайтал, хууль бус агнуур, зохисгүй ашиглалт орж байна. Мал аж ахуй эрхлэх уламжлалт арга барил өөрчлөгдсөн, хөдөө аж ахуйд газар, бэлчээрийн ургамлын нөөцийг хэтрүүлэн ашиглах зэргээс үүдэлтэй экосистемд үзүүлэх дарамт нь уур амьсгалын өөрчлөлттэй хавсарснаас амьтан, ургамлын аймгийн амьдрах орчин доройтож, тархацын хүрээ улам бүр хумигдаж, тэдгээрийн нөөц хомсдож байгаа нь устах аюулд ороод байгаа зүйлийн тоог нэмэх үндсэн шалтгаан болж байна.

2. Төрөөс Тогтвортой хөгжлийн талаар авч хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөр

Баримт 1.3.

“Төрөөс экологийн талаар баримтлах бодлого” (1997 он), “Монголын биологийн төрөл зүйлийг хамгаалах үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр” (1996 он), “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого” (2005 он), “Ой, мод боловсруулах үйлдвэрлэлийг сэргээх, тухайн чиглэлээр байгуулагдсан тосгоны хүн амын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний хөтөлбөр” (2010 он), “Ойн тухай үндэсний хөтөлбөр” (2001 он), “Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөр (2005 он) зэрэг бодлого, хөтөлбөрт ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх асуудалтай холбоотой бодлого, тодорхой зорилтуудыг дэвшүүлж, тэдгээрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

3. Ойн санд гарч буй өөрчлөлт

Баримт 1.4.

Жил тутам ойн талбайн 5 орчим хувь доройтож байна. Ойн сангаас жил бүр ойролцоогоор 600 мянган кубметр мод бэлтгэж, нилээдгүй хэмжээний талбай түймэрт өртөж, ойн санг доройтуулж байна. Үүний зэрэгцээ уул уурхай, малын тооны өсөлт, хотжилтын нөлөөгөөр ойн сан хомсдож байна. Ойн доройтлоос улбаалан амьтдын амьдрах орчин болоод ойн бүтээгдэхүүн шууд хомсдон, усны эх ундарга ширгэж байгаа нь хүнс, түлээгээр гачигдах зэргээр хүний хөгжилд шууд бусаар сөрөг нөлөө үзүүлж байна (Засгийн газар, 2011). Модыг зөвхөн түлээний болон барилга байгууламж барих зорилгоор тайрч, огтолдог бөгөөд мод боловсруулах орчин үеийн техник, технологи нэвтрээгүйгээс огтолсон модны дөнгөж 27 хувийг ашиглаж байна. Манай улсын ойн талбайн сүүлийн 12 жилийн өөрчлөлтөөс үзэхэд ойгоор бүрхэгдсэн талбай 289,2 мян.га-аар хорогдсон байна. Ойн сангийн ойгоор бүрхэгдээгүй талбайг газрын төрлөөр нарийвчлан авч үзвэл тармаг мод 3476,7 мян.га, шатсан ой 1196,8 мян.га, мод бэлтгэсэн талбай 124,1 мян. га, хөнөөлт шавжид нэрвэгдсэн талбай 95.7 мян. га, байгалийн гамшигт нэрвэгдсэн ой 0.9 мян. га, хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөгөөр эвдрэлд орсон 3,7 мян.га байна (БОНХЯ, 2012).

4. Газрын нэгдмэл санд гарч буй өөрчлөлт

Баримт 1.5.

Байгаль нь тодорхой хэмжээгээр доройтсон нутагт хүн ам нь амьдардаг дэлхийн 150 улстай харьцуулахад Монгол улс 12-т бичигддэг (NHDR 2011) нь газрын доройтлын хүн амд үзүүлэх сөрөг нөлөө нь манай орны хувьд илүү эмзэг болохыг харуулж байна.

Монгол улсын газрын нэгдмэл сангийн 73.8% нь хөдөө аж ахуйн газар, 9.1% нь ойн сан бүхий газар, 15.9% нь тусгай хэрэгцээний газар байдаг (Үндэсний статистикийн газар 2013). Хот тосгон, бусад суурин газар болон зам, шугам сүлжээний газар нийлээд 0.7%, усны сан бүхий газар 0.4%-ийг эзэлдэг байна. Бэлчээр, хадлангийн талбайн хэмжээ 2013 оны байдлаар 112.7 сая га буюу хөдөө аж ахуйн нийт газрын 97.7%-ийг эзэлж байна. 2013 оны статистик мэдээллээс үзэхэд доройтолд орсон 9 сая га газар бүртгэгдсэний 97.7% нь бэлчээр, хадлангийн газарт, 0.43% нь тариалангийн талбайд, 1.7% нь ойн сан бүхий газарт, 0.12% нь уул уурхай, зам барилгын ажлаас үүдэлтэй ухагдаж эвдэрсэн газарт ногдож байна (Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2013). Монгол улсад 1990 онд эхэлсэн нийгэм, эдийн засгийн өөрчлөлт хөдөөгийн иргэдийн аж амьдралд, дагаад байгаль экологид багагүй хэмжээгээр нөлөөлсөн билээ. Үүний нэг нь тасралтгүй өсч буй малын тоо, сүргийн бүтцэд ямааны эзлэх хувь нэмэгдсэн гэж үзэж болох юм. 2000 оны үед манай орны бэлчээрийн 20%-д доройтол илэрч байсан бол 2010 онд нийт бэлчээрийн 70% тодорхой хэмжээгээр доройтсон гэж судлаачид дүгнэжээ (IFAD-GEF project Mongolia, 2010).

Тогтвортой хөгжлийн асуудлыг микро түвшинд харвал:

Цөлжилтийн нэн хүчтэй зэрэглэлд өртсөн Дорноговь аймгийн Замын-Үүд сумын зургийг ажиглая.



Энэ зурган дээрх цөлжилтөд юу нөлөөлсөн бэ?

Чийг дутагдалтай буюу ууршилт нь тунадаснаасаа давуу уур амьсгалын нөхцөлтэй нутаг дэвсгэрийн ерөнхийд нь цөл гэсэн ангилалд хамруулдаг. Жилд 250мм- ээс бага хур тунадастай газар цөл үүсэх нөхцөл бүрдэж байдаг. *Тэгвэл танай нутагт жилд хэр хэмжээний хур тунадас унадаг вэ? Багш та сурагчдаараа цөлжилтийн эрчимжилтийг бууруулахын тулд юуг хийж чадах вэ?*



Хөрсний доройтол, цөлжилтийн эрчим, элсний нүүдлийг бууруулахын тулд эко сургуулийн хийсэн ажлуудыг дараах зургаар үзүүлж байна. Багш та санаа авч өөрийн болон сурагчдынхаа хүрээлэн буй орчинд илүү ихийг хийх боломж байгаа.

Улсын хэмжээнд бус харин гэр- сургуулийнхаа хооронд байх гудамж, талбайд элсний нүүдлийг барих, зогсоох урт үндэстэй, модлог ургамал түүнчлэн салхины хүчийг сааруулах 60см- ээс дээш өндөртэй бут сөөгийг тарих нь тохиромжтой гэж олон улсын судлаач эрдэмтэд үздэг.

Эх сурвалж:

Лейф Остлсон, Злас Сандолл, Иохан Охман, Тогтвортой хөгжлийн боловсрол. Бит пресс, Улаанбаатар, 2014 он

БСШУЯ, Ерөнхий боловсролын сургалт, үйл ажиллагаанд тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг тусган, хэрэгжүүлэх үндсэн чиглэл, шаардлага. ВСИ, Улаанбаатар, 2016 он

ЮНЕСКО, Цөлийн цэцэрлэг: Цөлжилтийг сааруулах боловсролын гарын авлага. Улаанбаатар, 2016 он

<http://www.unesco.mn/p/47>

<http://www.eic.mn/>

Мэдээллийг эмхтгэсэн: 3.Баярмаа (БМДИ-ийн байгалийн шинжлэл, газарзүйн сургалт хариуцсан арга зүйч)
Ц.Алтантуяа (Эрдмийн өргөө цогцолбор сургуулийн газарзүйн багш)